

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНААС БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ИРГЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАРУУД

Загвар А. Шинээр харилцагчаар бүртгүүлж үйлчилгээ авах итгэмжлэл;

Загвар Б. Онлайнар буюу зайнаас данс нээлгэсэн бөгөөд тус дансаа баталгаажуулж нэмэлт үйлчилгээ авах итгэмжлэл;

Загвар В. Худалдаа, хөгжлийн банканд харилцагчаар бүртгүүлж байсан боловч банктai Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж байгаагүй харилцагчийн үйлчилгээ авах итгэмжлэл /Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах, бусад үйлчилгээ авах итгэмжлэл/;

Загвар Г. Бусад буюу Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээг банктai байгуулсан, дансаа онлайнар нээгээгүй харилцагчийн итгэмжлэл

Жишээ: ХХБанканд хүүхдийн мөнгө хүлээн авах данс нээлгэх итгэмжлэл;

Төлөөлүүлэгч дээр дурдсан загваруудаас өөрөөр итгэмжлэлээ тодорхойлох, томъёолох бүрэн боломжтой боловч тухайн итгэмжлэлтэй холбоотой тодорхойгүй, эргэлзээтэй нөхцөл үүсвэл банк итгэмжлэлийг хүлээж авахгүй байж болохыг харгалзан үзнэ үү.

Санамж:

1/ Итгэмжлэлд төлөөлөгчид олгож байгаа эрхийг тодорхой заах /нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хийх, эрхийг аль нэг данстай холбоотой өгөх, эсхүл бүх дансанд хамааруулах, аливаа эргэлзээ үүсгэж болзошгүй байдлаар томъёолохоос зайлсхийх, эрх олгохдоо өөрт үүсэж болзошгүй эрсдэлийг тооцох/ нь зүйтэй. Мөн шинээр харилцагчаар бүртгүүлж данс нээлгэх тухай итгэмжлэлд банканд бүртгүүлэх **холбоо барих утас, хүчинтэй и-мейл хаягийн мэдээллээ** заавал давхар тусгасан байх шаардлагатай.

2/ Шинээр харилцагчаар бүртгүүлж буй тохиолдолд итгэмжлэлд тусгасан и-мэйл хаягт илгээсэн холбоосоор дамжин нэвтэрч банканд шаардлагатай үндсэн мэдээллийг бөглөн ирүүлэх шаардлагатай.

3/ Худалдаа, хөгжлийн банктai **нэгэнт Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж** данс нээлгэсэн этгээд бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар итгэмжлэл ирүүлэх тохиолдолд **харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээнд өөрийг нь төлөөлөн гарын үсэг зурах эрх олгож байгаа талаар тусгах шаардлагагүй.** Зөвхөн өөрийг нь төлөөлөн ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ авах эрх олгож байгаа талаар тодорхой тусгах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, дансны дугаарыг заавал тусгана.

4/ Харилцагч нэг дансанд хэдэн ч карт холбон ашиглах боломжтой байдаг бөгөөд **хэрэв хэд хэдэн карт эзэмшдэг харилцагч карттай холбоотой үйлчилгээ** авахаар итгэмжлэл олгож байгаа тохиолдолд дансны дугаараас гадна **картын дугаар тусгах** шаардлагатай.

5/ Итгэмжлэлийн хүчинтэй хугацааг тодорхой тусгаж ирүүлнэ. Өөрөөр хэлбэл, **сар, жил**-ийн аль хугацаагаар нь олгож байгаа талаар доогуур нь тодорхой зуран, итгэмжлэлийг үйлдэн ирүүлэх шаардлагатай.

**Худалдаа, хөгжлийн банкны харилцагчид
итгэмжлэлээр үзүүлэх иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт***

✓ Харилцагчийг шинээр бүртгэх	✓ Картанд данс нэмэх, картнаас данс салгах
✓ Харилцагчийн мэдээлэл шинэчлэх	✓ Бэлэн зарлагын гүйлгээ хийх
✓ Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах	✓ Хадгаламжийн дэвтрийн соронзон тууз, пин код өөрчлөх, устгах
✓ Дансны хуулга авах	✓ Дансны төлөв өөрчлөх буюу түр идэвхгүй, зогсоосон төлөвтэй дансдыг идэвхжүүлэх
✓ Дансны тодорхойлолт авах	✓ Бэлэн бус шилжүүлгийн гүйлгээ хийх
✓ MoneyGram үйлчилгээгээр хийсэн шилжүүлгийн тодорхойлолт авах	✓ Гадаад шилжүүлэг хийх
✓ Дансны нэгдсэн санд бүртгүүлэх	✓ Цахим банкны үйлчилгээнд шинээр бүртгүүлэх
✓ Шинээр данс нээлгэх / харилцах данс, хадгаламжийн данс, хүүхдийн нэрийн данс, тэтгэвэрийн данс гэх мэт /	✓ Цахим банкны үйлчилгээний утасны дугаар солих
✓ Дансанд хамтран эзэмшигч нэмэх, данснаас хамтран эзэмшигч хасах / хэнийг нэмэх, хасах талаар тодорхой тусгах	✓ Цахим банкны үйлчилгээний и-мэйл солих
✓ Дансанд хамтран эзэмшигчээр бүртгүүлэх, /хүүхдийн нэрийн данс, мөнгөн хадгаламжийн данс гэх мэт /	✓ Цахим банкны үйлчилгээний нэвтрэх нэр солих
✓ Хадгаламжийн хугацаа сунгах, цуцлах, автомат сунгалт хийлгэх	✓ ОTR буюу нэг удаагийн нууц үгийн блок гаргах
✓ Данс бэлнээр болон бэлэн бусаар хаах	✓ Васко блок гаргах
✓ Шинэ үйлчилгээнд бүртгүүлэх /тогтмол шилжүүлэг, хялбар хуримтлал /	✓ Цахим банкны үйлчилгээний эрх сунгах
✓ Үйлчилгээ цуцлах	✓ Мост Мони үйлчилгээний утасны дугаар солих
✓ Карт шинээр захиалах	✓ Мост Мони үйлчилгээний и-мэйл солих
✓ Карт дахин захиалах	✓ Мост Мони үйлчилгээ хаах
✓ Дэд карт эзэмшигч нэмэх	✓ Цахим банкны үйлчилгээний багц ахиулах, өөрчлөх
✓ Захиалсан картыг хүлээн авах /пин кодтой эсхүл пин кодгүй /	✓ Мэдэгдлийн үйлчилгээнд данс нэмэх
✓ Картын төлөв өөрчлөх /картыг түр хаах, картыг нээх /	✓ Мэдэгдлийн үйлчилгээнд данс хасах
✓ Картын лимит өөрчлөх	✓ Мэдэгдлийн үйлчилгээний эрх хаах
✓ Картын үндсэн данс солих	✓ ПОС терминал нэмэлтээр авах
✓ Картын пин код шинээр авах болон солих, блок гаргах	✓ Мерчантын орлого хүлээн авах данс солих
✓ АТМ-д хураагдсан карт авах	✓ Мерчантын хуулга авах систем (cardcentre.mn)-д бүртгүүлэх
✓ Картын интернэт пин код авах	✓ Мерчантын нэр, хаяг байршил, утас, мэдээлэл өөрчлөх
✓ Карт бүрмөсөн хаах	✓ ПОС-ын НӨАТ-тай холбоотой тохиргоо хийлгэх
✓ Хаасан картын дансны үлдэгдлийг авах	✓ QR кодоор гүйлгээ хийх хүсэлт болон гэрээ хийх
✓ Тэтгэвэрийн зээл авах, зээлийн гэрээнд гарын үсэг зурах /Авах зээлийн хэмжээ, хугацааг тодорхой заана/	

*Дээр дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдлийг иргэн, харилцагч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан авах/хийх боломжтой бөгөөд **итгэмжлэлээр олгож буй эрх хэсэгт** өөрийг нь төлөөлөн ямар үйлчилгээ авах эрх олгож байгаа талаар тодорхой бичсэн байх шаардлагатай.

- Олгох эрхүүдийг итгэмжлэлийн загварын “...Энэхүү итгэмжлэлийн дагуу...” гэсэн хэсэгт нэмж тусгана.

ХХБ-нд бүртгэлгүй буюу өмнө нь бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаагүй иргэн доорх загварын дагуу итгэмжлэлийг үйлдэн ирүүлнэ.

Загвар А. Шинээр харилцагчаар бүртгүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээ авах ИТГЭМЖЛЭЛ-ийн загвар

.... оны дугаар
сарын-ны өдөр

_____ улс
_____ хот

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн хаягт оршин суух -ын би /цаашид “Төлөөлүүлэгч” гэх/, хаягт оршин суух -ын-д /цаашид “Төлөөлөгч” гэх/:

Энэхүү итгэмжлэлийн дагуу Худалдаа, хөгжлийн банканд миний нэр дээр данс нээлгэх, харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж гарын үсэг зурах, харилцагчаар бүртгүүлэх, харилцагчаар бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх, нээсэн дансанд дотоодын/ олон улсын карт захиалах, зарлагын гүйлгээ гаргах эрхтэй Интернет банк /Ти Ди Би онлайн/-ны үйлчилгээ нээлгэх, холбуулах, нууц үгийг хүлээн авах и-мейл хаягаар хаягийг бүртгүүлэх, бүртгэлтэй холбоо барих утасны дугаараар дугаарыг бүртгүүлэх, зарлагын гүйлгээ гаргах, тэдгээрт холбогдох хүсэлт гаргах, маягт бөглөх, гэрээ, хэлцлийг байгуулах зэрэг үйлдэл хийх эрхийг үүгээр олгож байна.

Итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн сар/жил-ийн хугацаанд хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Энэхүү итгэмжлэлийг олгож буй миний бие итгэмжлэлийн агуулга, үр дагаварыг ойлгож, уншиж танилцсан ба бусдын дарамт шахалт, бусад хүчин зүйлд авталгүйгээр, хүсэл зоригоо илэрхийлэн үйлдсэн болно.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ:

ТӨЛӨӨЛӨГЧ:

/нэр/ /гарын үсэг/

/нэр/ /гарын үсэг/

Регистрийн дугаар:
Утас:

Регистрийн дугаар:
Утас:

Ковидын хөл хорионы үед Засгийн газраас олгосон мөнгөн дэмжлэгийг авах зориулалтаар онлайнаар данс нээсэн харилцагч нь тус дансыг баталгаажуулж, өөрийн биеэр эсхүл **төлөөлөгчөөр** дамжуулан банктай шаардлагатай гэрээг байгуулснаар Банкны бусад үйлчилгээг авах боломжтой болох ба тус харилцагчид доорх загварын дагуу итгэмжлэлийг үйлдэн ирүүлнэ.

Загвар Б. Зайнаас нээсэн дансыг баталгаажуулах ИТГЭМЖЛЭЛ-ийн загвар

..... оны дугаар
сарын-ны өдөр

_____ улс
_____ хот

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн хаягт оршин суух -ын би /цаашид “Төлөөлүүлэгч” гэх/, хаягт оршин суух -ын-д /цаашид “Төлөөлөгч” гэх/:

Энэхүү итгэмжлэлийн дагуу Худалдаа, хөгжлийн банканд миний онлайнаар нээсэн/дансны дугаар заавал тусгах/ дансыг баталгаажуулах буюу харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж гарын үсэг зурах, харилцагчаар бүртгүүлэх, харилцагчаар бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх, тус дансанд дотоодын/ олон улсын карт захиалах, зарлагын гүйлгээ гаргах эрхтэй Интернэт банк /Ти Ди Би онлайн/-ны үйлчилгээ нээлгэх, холбуулах, нууц үгийг хүлээн авах и-мейл хаягаар хаягийг бүртгүүлэх, бүртгэлтэй холбоо барих утасны дугаараар дугаарыг бүртгүүлэх, зарлагын гүйлгээ гаргах, тэдгээрт холбогдох хүсэлт, маягтыг бөглөх, гэрээ, хэлцлийг байгуулах зэрэг үйлдэл хийх эрхийг үүгээр олгож байна.

Итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн сар/жил-ийн хугацаанд хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Энэхүү итгэмжлэлийг олгож буй миний бие итгэмжлэлийн агуулга, үр дагаварыг ойлгож, уншиж танилцсан ба бусдын дарамт шахалт, бусд хүчин зүйлд авталгүйгээр, хүсэл зоригоо илэрхийлэн үйлдсэн болно.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ:

ТӨЛӨӨЛӨГЧ:

/нэр/ /гарын үсэг/

/нэр/ /гарын үсэг/

Регистрийн дугаар:
Утас:

Регистрийн дугаар:
Утас:

ХХБ нь 2018 оны 7 дугаар сараас хойш харилцагчид үзүүлэх үйлчилгээний суурь асуудлуудыг тодорхойлох, цахим үйлчилгээний боломжуудыг нээх үүднээс Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж эхэлсэн. Харилцагч энэ хугацаанаас өмнө банканд харилцагч болсон боловч уг гэрээг байгуулаагүй харилцагчид доорх итгэмжлэлийн загварыг хэрэглэх нь зүйтэй.

Загвар В. Банканд өмнө биечлэн нээсэн данстай боловч Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулаагүй харилцагчийн ИТГЭМЖЛЭЛ-ийн загвар

..... оны дугаар _____ улс
 сарын-ны өдөр _____ хот

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн хаягт оршин суух -ын би /цаашид “Төлөөлүүлэгч” гэх/, хаягт оршин суух -ын-д /цаашид “Төлөөлөгч” гэх/:

Энэхүү итгэмжлэлийн дагуу Худалдаа, хөгжлийн банктай миний өмнөөс харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж гарын үсэг зурах, харилцагчийн мэдээллийг шинэчилэх, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх, мөн миний нэр дээрх тоот дансанд дотоодын/ олон улсын карт захиалах, зарлагын гүйлгээ гаргах эрхтэй Интернэт банк /Ти Ди Би онлайн/-ны үйлчилгээ нээлгэх, холбуулах, нууц үгийг хүлээн авах и-мейл хаягаар хаягийг бүртгүүлэх, бүртгэлтэй холбоо барих утасны дугаараар дугаарыг бүртгүүлэх, зарлагын гүйлгээ гаргах, тэдгээрт холбогдох хүсэлт гаргах, маягт бөглөх, гэрээ, хэлцлийг байгуулах зэрэг үйлдэл хийх эрхийг үүгээр олгож байна.

Итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн сар/жил-ийн хугацаанд хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Энэхүү итгэмжлэлийг олгож буй миний бие итгэмжлэлийн агуулга, үр дагаварыг ойлгож, уншиж танилцсан ба бусдын дарамт шахалт, бусд хүчин зүйлд авталгүйгээр, хүсэл зоригоо илэрхийлэн үйлдсэн болно.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ:

ТӨЛӨӨЛӨГЧ:

 /нэр/ /гарын үсэг/

 /нэр/ /гарын үсэг/

Регистрийн дугаар:
 Утас:

Регистрийн дугаар:
 Утас:

Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээг банктай байгуулсан, дансаа онлайнгаар нээгээгүй бол доорх итгэмжлэлийн загварыг ашиглан итгэмжлэлийг үйлдэн ирүүлнэ.

Загвар Г. Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээтэй харилцагчийн ИТГЭМЖЛЭЛ-ийн загвар

.... оны дугаар
сарын-ны өдөр

_____ улс
_____ хот

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн хаягт оршин суух -ын би /цаашид “Төлөөлүүлэгч” гэх/, хаягт оршин суух -ын-д /цаашид “Төлөөлөгч” гэх/:

Энэхүү итгэмжлэлийн дагуу намайг төлөөлөн Худалдаа, хөгжлийн банкна дахь миний нэр дээрх тоот дансанд дотоодын/ олон улсын карт захиалах, зарлагын гүйлгээ гаргах эрхтэй Интернэт банк /Ти Ди Би онлайн/-ны үйлчилгээ нээлгэх, холбуулах, зарлагын гүйлгээ гаргах, тэдгээрт холбогдох хүсэлт гаргах, маягт бөглөх, гэрээ, хэлцлийг байгуулах эрхийг үүгээр олгож байна:

Итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн сар/жил-ийн хугацаанд хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Энэхүү итгэмжлэлийг олгож буй миний бие итгэмжлэлийн агуулга, үр дагаварыг ойлгож, уншиж танилцсан ба бусдын дарамт шахалт, бусд хүчин зүйлд авталгүйгээр, хүсэл зоригоо илэрхийлэн үйлдсэн болно.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ:

ТӨЛӨӨЛӨГЧ:

/нэр/ /гарын үсэг/

/нэр/ /гарын үсэг/

Регистрийн дугаар:
Утас:

Регистрийн дугаар:
Утас:

Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь ХХБ-нд бүртгэлгүй тохиолдолд “Харилцагчаар бүртгүүлэх, Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах” эрхийг итгэмжлэлээр заавал олгосон байна.

Жишээ: ХХБанканд хүүхдийн мөнгө хүлээн авах данс нээлгэх ИТГЭМЖЛЭЛ-ийн загвар

.... оны дугаар _____ улс
 сарын-ны өдөр _____ хот

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн хаягт оршин суух -ын би /цаашид “Төлөөлүүлэгч” гэх/, хаягт оршин суух -ын-д /цаашид “Төлөөлөгч” гэх/:

Энэхүү итгэмжлэлийн дагуу Худалдаа, хөгжлийн банканд миний хүүхэд болох овогтой-ны/ний нэр дээр хүүхдийн нэрийн данс нээлгэх, мөнгөн хадгаламжийн данс нээлгэх, хүүхдийн нэрийн болон хадгаламжийн дансанд намайг хамтран эзэмшигчээр бүртгүүлэх, хүүхдийн нэрийн дансанд орох мөнгөн хөрөнгийг хүүхдийн хадгаламжийн дансанд автоматаар татагддаг үйлчилгээнд бүртгүүлэх, үүнтэй холбогдуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ болон мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж гарын үсэг зурах, харилцагчаар бүртгүүлэх, харилцагчаар бүртгүүлж, данс нээлгэхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх, тэдгээрт холбогдох хүсэлт гаргах, маягт бөглөх, гэрээ, хэлцлийг байгуулах зэрэг үйлдэл хийх эрхийг үүгээр олгож байна.

Итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн сар/жил-ийн хугацаанд хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Энэхүү итгэмжлэлийг олгож буй миний бие итгэмжлэлийн агуулга, үр дагаварыг ойлгож, уншиж танилцсан ба бусдын дарамт шахалт, бусд хүчин зүйлд авталгүйгээр, хүсэл зоригоо илэрхийлэн үйлдсэн болно.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ:

 /нэр/ /гарын үсэг/

ТӨЛӨӨЛӨГЧ:

 /нэр/ /гарын үсэг/

Регистрийн дугаар:
 Утас:

Регистрийн дугаар:
 Утас: